

Тунхаглалын эцсийн хувилбар  
2020 оны 01 дүгээр сар

УСНББОУС<sup>TM</sup>

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт<sup>TM</sup>

**2019 оны УСНББОУС-ын  
Сайжруулалтууд**



Улсын Секторын Нягтлан  
Бодох Бүртгэлийн Олон  
Улсын Стандартын Зөвлөл<sup>TM</sup>



**Улсын Секторын Нягтлан  
Бодох Бүртгэлийн Олон  
Улсын Стандартын Зөвлөл<sup>TM</sup>**

Энэхүү баримт бичгийг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ<sup>TM</sup>) боловсруулж, баталсан.

УСНББОУСЗ-ийн зорилго нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн өндөр чанартай стандартуудыг тогтоох, тэдгээрийн мөрдөлт ба хэрэгжүүлэлтэнд туслалцаа үзүүлэх, ингэснээр дэлхий дахини практикын чанар ба туштай байдлыг сайжруулах, улсын секторын санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм.

Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагууд, үүн дотроо үндэсний, бүсийн, орон нутгийн застийн газрууд болон засгийн газрын холбогдох агентлагууд ашиглахад зориулсан УСНББС<sup>TM</sup> ба Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ)-уудыг гаргадаг.

УСНББОУС нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-д хамааралтай бөгөөд бүрэн эрхтэй байдаг. СБПУ-ууд нь санхүүгийн тайланг биш, харин нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан илтгэл (НЗСТИ)-ийг бэлтгэх сайн практикын талаархи заавар удирдамжаар хангадаг тунхаглалууд юм. УСНББОУС-аас ялгаатай нь, СБПУ нь шаардлагуудыг тогтоодоггүй. Санхүүгийн тайлан биш, харин НЗСТИ-тэй холбоотой бүх тунхаглалууд нь одоогоор СБПУ-ууд байна. СБПУ-ууд нь мэдээлэлд хамаарах баталгааны (хэрэв байгаа бол) түвшний талаархи заавар удирдамжаар хангадаггүй.

УСНББОУСЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах бүтэц болон үйл явцад Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо<sup>TM</sup> (ДНБХ<sup>TM</sup>) дэмжлэг үзүүлдэг.

Зохиогчийн эрх © 2020 оны 01 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, зөвшөөрлийн талаархи мэдээллийг 28-р хуудаснаас үзнэ үү.

# **2019 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД**

## **АГУУЛГА**

---

УСНББОУС-ын Сайжруулалтууд

Хуудас  
4

---

## УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

### Зорилго

1. 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтуудын зорилго нь оролцогч талуудын дэвшүүлсэн асуудлуудыг авч үзэхийн тулд УСНББОУС-д сайжруулалт хийх явдал юм.

### Харгалзан үзсэн УСНББОУС

2. 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд нь хоорондоо хамааралгүй нэмэлт өөрчлөлтүүдийн цуглуулга байдлаар УСНББОУС-д хийсэн материаллаг бус өөрчлөлтүүдийг авч үзсэн. 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-д тусгасан нэмэлт өөрчлөлтүүд нь оролцогч талуудаас хүлээн авсан санал шүүмжлэлд үндэслэсэн.

### УСНББОУС-ЫН Сайжруулалтууд

УСНББОУС	Өөрчлөлтийн товч тойм
УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн үр дунд Бусад УСНББОУС-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд	
УСНББОУС 5, Зээлийн Өртөг	УСНББОУС 41-ийг гаргах үед санамсаргүйгээр орхигдуулсан, зээлийн өргтгийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоотой заавар удирдамжийг шинэчлэн баяжуулахын тулд УСНББОУС 5-д оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 1а-г</b> үзнэ үү).
УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга	УСНББОУС 41-ийг гаргах үед санамсаргүйгээр орхигдуулсан, хейжийн болон зээлийн эрсдлийн талаархи үлгэрчилсэн жишээний хувьд УСНББОУС 30-д оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 1б-г</b> үзнэ үү).
УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга	УСНББОУС 41-ийг гаргах үед санамсаргүйгээр орхигдуулсан, санхүүгийн баталгааны гэрээний тайлагналтай холбоотой заавар удирдамжийг шинэчлэн баяжуулахын тулд УСНББОУС 30-д оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 1в-г</b> үзнэ үү).
УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх	УСНББОУС 41-ийг гаргах үед санамсаргүйгээр орхигдуулсан, аккруэл суурьт УСНББОУС-ыг анх мөрдөхөд санхүүгийн хэрэглүүрийг ангилах талаархи заавар удирдамжийг шинэчлэн баяжуулахын тулд УСНББОУС 33-д оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 1г-г</b> үзнэ үү).
УСНББОУС 13, Түрээс	Үнэ цэнийн бууралтын хувьд олон улсын ба/буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн бусад стандартын цар хүрээг харгалзах одоогийн заалтын оронд УСНББОУС-ын тохиromжтой заалтыг тусган оруулахын тулд УСНББОУС 13-д оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 2-ыг</b> үзнэ үү).
УСНББОУС 13, Түрээс ба УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө	УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийг батлан гаргах үед устгах хэрэгтэй байсан шилжилтийн үеийн нөхцлүүдийг хасахын тулд оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 3а ба Хэсэг 3б-г</b> үзнэ үү).
УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт ба УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт	УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө ба УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө-ийн цар хүрээнд хамаарах, дахин үнэлсэн хөрөнгүүдийг тайлгагнах үнэ цэнийн бууралтын заавар удирдамжийн тууштай байдлыг хангахын тулд оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 4а ба Хэсэг 4б-г</b> үзнэ үү).
УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх	УСНББОУС 33 дахь төсөөлөн тооцсон өргтгийг уг Стандартын гол зарчмуудтай нийцүүлэхийн тулд түүний хэрэгжүүлэх заавар удирдамжид оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 5-ыг</b> үзнэ үү).

2019 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл	УСНББОУС 40-ийг гаргах үед санамсаргүйгээр орхигдуулсан, хүчин төгөлдөр болох хугацааны параграфыг тусгахын тулд оруулсан нэмэлт өөрчлөлт ( <b>Хэсэг 6-г үзнэ үү</b> )
------------------------------------	--

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 1а

### УСНББОУС 5, Зээлийн Өртөг-т оруулсан нэмэлт өөрчлөлт

6-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 42Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

#### Тодорхойлолт

...

#### Зээлийн өртөг

...

6. Зээлийн өртөгт дараах зүйлс багтаж болно:

- (а) Банкны овердрафт, богино болон урт хугацаат зээлийн хүр УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-т заасанчлан, үр ашигт хууний арга ашиглан тооцоолсон хүүний зардал;
- (б) Зээлтийн холбоотой хөнгөлөлт, урамшууллын хорогдуулга; [Хассан]
- (в) Зээлтийн гэрээтэй холбоотойгоор гарсан нэмэлт өртөг зардлын хорогдуулга; [Хассан]
- (г) Санхүүгийн түрээс болон үйлчилгээний концессын хэлцэлтэй холбоотой санхүүгийн хураамж; ба
- (д) Гадаад валютын зээлээс үүссэн бөгөөд хүүний зардлын тохируулга гэж үзэх тохиолдолд ханшийн зөрүү.

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

42Д. 2019 оны 01 дүгээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 6-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеудийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

#### Дүгнэлтийн Үндэслэл

...

#### 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дунд УСНББОУС 5-д хийсэн хянан засварлалт

ДҮ2. 6-р параграфын нэмэлт өөрчлөлт нь зээлийн өртгийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоотой заавар удирдамжийг УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн үр дунд шинэчлэн баяжуулах бөгөөд УСНББОУС 41-ийг гаргах үед үүнийг санамсаргүйгээр орхигдуулсан байсан. УСНББОУСЗ нь эдгээр жижиг нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 16

### УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

ХЗҮ13А-ХЗҮ13В ба ХЗҮ22А-ХЗҮ22Г параграфыг шинээр нэмсэн. ХЗҮ23-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

#### Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү заавар удирдамж нь УСНББОУС 30-ийг дагалдах боловч түүний салигүй бүрэлдэхүүн хэсэг биши юм.

...

#### Хейжийн нягтлан бодох бүртгэл (28А-28В параграф)

ХЗҮ13А. Байгууллага нь хейжийн хэрэглүүр гэж сонгосон зүйлстэй холбоотой дунгүүдийг хүснэгтэн хэлбэрээр тодруулахыг УСНББОУС 30-ийн 28А параграфаар шаардсан байдаг. Уг мэдээллийг хэрхэн тодруулж болохыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

	<u>Хейжийн хэрэглүүрийн нэрлэсэн дун</u>	<u>Хейжийн хэрэглүүрийн дансны унэ</u>		<u>Хейжийн хэрэглүүрийг тусгах санхүүгийн байдлын тайлангийн морийн зүйл</u>	<u>20Х1 оны хувьд хейжийн үр дунгүй байдлыг тооцоолоход ашигласан бодит унэ цэнийн өөрчлөлт</u>
		<u>Хөрөнгө</u>	<u>Өр төлбөр</u>		
<b><u>Мөнгөн гүйлгээний хейж</u></b>					
<u>Бараа бүтээгдэхүүний үнийн эрдэл</u>					
- Форвард борлуулалтын гэрээ	<u>XX</u>	<u>XX</u>	<u>XX</u>	<u>Мөрийн зүйл XX</u>	<u>XX</u>
<b><u>Бодит унэ цэнийн хейж</u></b>					
<u>Хүүний түвшний эрдэл</u>					
- Хүүний түвшний споп	<u>XX</u>	<u>XX</u>	<u>XX</u>	<u>Мөрийн зүйл XX</u>	<u>XX</u>
<b><u>Валютын ханшийн эрдэл</u></b>					
- Гадаад валютын зээл	<u>XX</u>	<u>XX</u>	<u>XX</u>	<u>Мөрийн зүйл XX</u>	<u>XX</u>

ХЗҮ13Б. Байгууллага нь хейжийн зүйл гэж сонгосон зүйлстэй холбоотой дунгүүдийг хүснэгтэн хэлбэрээр тодруулахыг УСНББОУС 30-ийн 28Б параграфаар шаардсан байдаг. Уг мэдээллийг хэрхэн тодруулж болохыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

	<u>Хейжийн зүйлийн дансны унэ</u>	<u>Хейжийн зүйлийн дансны унэд тусгагдсан, уг хейжийн зүйлд хамаарах бодит унэ цэнийн хейжийн залруулгын хуримтлагдсан дун</u>	<u>Хейжийн зүйлийг тусгах санхүүгийн байдлын тайлангийн морийн зүйл</u>	<u>20Х1 оны хувьд хейжийн үр дунгүй байдлыг тооцоолоход ашигласан бодит унэ цэнийн өөрчлөлт</u>	<u>Мөнгөн гүйлгээний хейжийн нөөц</u>

	<u>Хөрөнгө</u>	<u>Өр төлбөр</u>	<u>Хөрөнгө</u>	<u>Өр төлбөр</u>			
<b>Мөнгөн гүйлгээний хейж</b>							
<u>Бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэл</u>							
- Урьдчилан таамагласан борлуулалт	X/гүй	X/гүй	X/гүй	X/гүй	X/гүй	XX	XX
- Зогсоосон хейж (Урьдчилан таамагласан борлуулалт)	X/гүй	X/гүй	X/гүй	X/гүй	X/гүй	X/гүй	XX
<b>Бодит үнэ цэнийн хейж</b>							
<u>Хүүний түвшний эрсдэл</u>							
- Зээлийн өглөг	-	XX	-	XX	Мөрийн зүйл XX	XX	X/гүй
Зогсоосон хейж (Зээлийн өглөг)	-	XX	-	XX	Мөрийн зүйл XX	X/гүй	X/гүй
<u>Валютын ханшийн эрсдэл</u>							
- Арилжааны баталгаа	XX	XX	XX	XX	Мөрийн зүйл XX	XX	X/гүй

ХЗҮ13В. Байгууллага нь хэйжийн нягтлан бодох буртгэлийг хэрэглэсний үр дунд түүний санхүүгийн үр дүнгийн тайландаа нөлөө узуулэх дунгүүдийг хүснэгтэн хэлбэрээр тодруулахыг УСНББОУС 30-ийн 28В параграфаар шаардсан байдаг. Уг мэдээллийг хэрхэн тодруулж болохыг дараах жишээнд углэрчлэн харуулав.

<u>Мөнгөн гүйлгээний хейж<sup>(a)</sup></u>	<u>Цэвэр төлөв байдлын хэйжийн үр дунд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн тусдаа мөрийн зүйл<sup>(b)</sup></u>	<u>Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн хэйжийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлт</u>	<u>Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн хэйжийн үр дунгүй байдал</u>	<u>Ашиг, алдагдал дахь мөрийн зүйл (хэйжийн үр дунгүй байдал</u>	<u>Мөнгөн гүйлгээний хэйжийн нөөцөөс ашиг, алдагдалд дахин ангилсан дун</u>	<u>Дахин ангиллын улмаас ашиг, алдагдалд нөлөө узуулсан мөрийн зүйл</u>
<u>Бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэл</u>						
- Х бараа	X/гүй	XX	XX	Мөрийн зүйл XX	XX	Мөрийн зүйл XX
- Зогсоосон хейж	X/гүй	X/гүй	X/гүй	X/гүй	XX	Мөрийн зүйл XX
(a) Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайландаа (мөнгөн гүйлгээний хэйжийн нөөцөд) толилуулах мэдээлэл нь эдгээр мэдээлэлтэй адил дэлгэрэнгүй байдлын түвшнитэй байвал зохино. (б) Энэхүү тодруулга нь зөвхөн гадаад валютын эрсдлийн мөнгөн гүйлгээний хэйжид хамаарна.						

<u>Бодит үнэ цэнийн хейж</u>	<u>Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн хэйжийн үр дунгүй байдал</u>	<u>Ашиг, алдагдал дахь мөрийн зүйл (хэйжийн үр дунгүй байдалыг агуулсан)</u>
<u>Хүүний түвшний эрсдэл</u>	XX	Мөрийн зүйл XX
<u>Валютын ханшийн эрсдэл</u>	XX	Мөрийн зүйл XX

...

**Зээлийн эрсдэл (42А-43, МЗҮ8А-МЗҮ10-р параграф)**

ХЗҮ22А. УСНБОУС 30-ийн 42А-42П параграфаар шаардсан тодруулгыг байгууллага нь бэлтгэж болох боломжит арга замуудыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан. Гэвч уг тодруулгын шаардлагуудыг мөрдөх боломжит бүх арга замуудыг эдгээр үлгэрчилсэн жишээнд авч үзээгүй болно.

**4И ба 42К параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах**

ХЗҮ22Б. 42И-42К параграфаар шаардсан алдагдлын хасагдуулгын өөрчлөлтөнд хувь нэмрээ оруулах, санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд тухайн тайлант үеийн туршид орсон мэдэгдэхүйц өөрчлөлт болон алдагдлын хасагдуулгын өөрчлөлтийн талаархи мэдээлээр хангах нэг арга замыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Худалдан авсан буюу үүсгэн гаргасан зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгөнд хамаарах шаардлагуудыг энэ жишээнд үлгэрчлэн харуулаагүй болно.

	<u>12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал</u>	<u>Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал (хамтад нь унэлсэн)</u>	<u>Нийт хугацаанд хүлээгдэж бий зээлийн алдагдал (тус тусад нь унэлсэн)</u>	<u>Зээлийн үнэ цэнийн бууралттай хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал</u>
<u>Моргейжийн зээл-Алдагдлын хасагдуулга</u>	<u>хүгэцаанд хүлээгдэж бий зээлийн алдагдал</u>	<u>хүгэцаанд хүлээгдэж бий зээлийн алдагдал (хамтад нь унэлсэн)</u>	<u>хүгэцаанд хүлээгдэж бий зээлийн алдагдал (тус тусад нь унэлсэн)</u>	<u>цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө (Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал)</u>
<u>Мянган ТН Алдагдлын хасагдуулга, 01-р сарын 01-нээр</u>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>
<u>01-р сарын 01-нээр хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүрээс хамаарсан өөрчлөлт:</u>				
- <u>Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалд шилжүүлэх</u>	<input checked="" type="checkbox"/>		<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>
- <u>Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгөнд шилжүүлэх</u>	<input checked="" type="checkbox"/>		<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>
- <u>12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалд шилжүүлэх</u>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>
- <u>Тайлант үед үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө</u>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>
<u>Үүсгэн гаргасан буюу худалдан авсан шинэ санхүүгийн хөрөнгө</u>	<input checked="" type="checkbox"/>			
<u>Данснаас хасалт Загвар/зээлийн параметруудийн өөрчлөлт</u>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>
<u>Ханшийн зөрүү ба бусад өөрчлөлт хөдөлгөөн</u>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>
<u>Алдагдлын хасагдуулга, 12-р сарын 31-нээр</u>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>

Алдагдлын хасагдуулгын өөрчлөлтөнд хувь нэмрээ оруулах, моргейжийн зээлийн нийт дансны үнэд орсон мэдэгдэхүйц өөрчлөлтууд:

- У бүсийн моргейжийн үндсэн багцыг худалдан авснаар орон сууцны моргейжийн зээлийн дансны үнэ нь “х” хувиар нэмэгдсэн, иймээс 12 сарын сууриар хэмждэг алдагдлын хасагдуулга харгалzan нэмэгдсэн.
- Тухайн бүсийн орон нутгийн зах зээлд уналт гарсны дараа, Зэт бүсийн “ХХ” ТН-ийн моргейжийн багцыг данснаас хасаж, “Х” ТН-ээр үнэ цэнэ буурсан гэсэн бодит нотолгоо бүхий санхүүгийн хөрөнгийн хувьд алдагдлын хасагдуулгыг бууруулсан.

- X бүс дэх ажилгүйдлийн хүлээгдэж буй нэмэгдэлт нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтайгаа тэнцүү тийм алдагдлын хасагдуулга бүхий санхүүгийн хөрөнгөнд цэвэр өсөлт гарахад хургэсэн бөгөөд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулгад “Х” ТН-ийн цэвэр өсөлт гарах шалтгаан болсон.

Моргайжийн зээлийн нийт дансны үнэд орсон мэдэгдэхүйц өөрчлөлтуудийг доор тайлбарлан харуулав:

<u>Моргайжийн зээл-Нийт дансны үнэ</u>	<u>12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал</u>	<u>Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал</u>	<u>Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал</u>	<u>Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө (Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал)</u>
<u>Мянган ТН</u>				
<u>Нийт дансны үнэ, 01-р сарын 01-нээр</u>	X	X	X	X
<u>Нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалд шилжүүлсэн, бие даасан санхүүгийн хөрөнгүүд</u>	(X)	-	X	-
<u>Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгөнд шилжүүлсэн, бие даасан санхүүгийн хөрөнгүүд</u>	(X)	-	(X)	X
<u>Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгөөс шилжүүлсэн, бие даасан санхүүгийн хөрөнгүүд</u>	X	-	X	(X)
<u>Хамтын сууриар үнэлсэн санхүүгийн хөрөнгө</u>	(X)	X	-	-
<u>Үүсгэн гаргасан буюу худалдан авсан шинэ санхүүгийн хөрөнгө</u>	X	-	-	-
<u>Данснаас хасалт</u>	-	-	(X)	(X)
<u>Үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө</u>	(X)	(X)	(X)	(X)
<u>Үл хүлээн зөвшөөрөлтөнд хүргэхгүй нэмэлт засварлалтаас хамаарсан өөрчлөлт</u>	(X)	-	(X)	(X)
<u>Бусад өөрчлөлт</u>	X	X	X	X
<u>Нийт дансны үнэ, 12-р сарын 31-нээр</u>	X	X	X	X

#### 42О ба 42П параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах

ХЗУ22В. Байгууллагын зээлийн эрсдэл өртөлт ба зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц төвлөрлийн талаархи мэдээллийг УСНББОУС 30-ийн 42О параграфын дагуу ханган бурдуулэх зарим арга замыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан. УСНББОУС 30-ийн 42О параграфын дагуу мэдээллийг тодруулахад ашигласан зэрэглэлийн тоо нь зээлийн эрсдлийн дотоод удирдлагын зорилгоор эрх бүхий албан тушаалтанд дотооддоо тайлагнахдаа уг байгууллагын ашигладаг тоотой нийцсэн байвал зохино. Гэвч зээлийн эрсдлийн зэрэглэлийн тувшиний талаархи мэдээллийг их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломжгүй ба анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг байгууллага нь УСНББОУС 41-ийн 83-р параграфын дагуу үнелхийн тулд тэрхүү хугацаа өнгөрсөн мэдээллийг ашигладаг бол тус байгууллага нь тэдгээр санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хугацаа өнгөрөлтийн төлөв байдлаар шинжилгээ хийнэ.

<u>Дотоод зэрэглэлийн тувшиэр харуулсан, зээлийн эрсдэл өртөлт</u>		
<u>20XX он</u> <u>Мянган ТН</u>	<u>Моргайжийн зээл</u> <u>Нийт дансны үнэ</u>	<u>Хөдөө аж ахуйн зээл</u> <u>Нийт дансны үнэ</u>

	<u>Нийт</u> хугацаа	<u>12 сарын</u> хугацаа	<u>Нийт</u> хугацаа	<u>12 сарын</u> хугацаа
<u>Дотоод зэрэглэл 1-2</u>	X	X	X	X
<u>Дотоод зэрэглэл 3-4</u>	X	X	X	X
<u>Дотоод зэрэглэл 5-6</u>	X	X	X	X
<u>Дотоод зэрэглэл 7</u>	X	X	X	X
<b><u>Нийт дун</u></b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

<b><u>Гадаад зэрэглэлийн түвшнээр харуулсан, зээлийн эрсдлийн төлөв байдал</u></b>				
<u>20XX он</u> <u>Мянган ТН</u>	<u>Моргейжийн зээл</u>		<u>Хөдөө аж ахуйн зээл</u>	
	<u>Нийт дансны унэ</u>		<u>Нийт дансны унэ</u>	
	<u>Нийт</u> хугацаа	<u>12 сарын</u> хугацаа	<u>Нийт</u> хугацаа	<u>12 сарын</u> хугацаа
<u>AAA-AA</u>	X	X	X	X
<u>A</u>	X	X	X	X
<u>BBB-BB</u>	X	X	X	X
<u>B</u>	X	X	X	X
<u>CCCC-CC</u>	X	X	X	X
<u>C</u>	X	X	X	X
<u>D</u>	X	X	X	X
<b><u>Нийт дун</u></b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

<b><u>Үл биелүүлэлтийн магадлалаар харуулсан, зээлийн эрсдлийн төлөв байдал</u></b>				
<u>20XX он</u> <u>Мянган ТН</u>	<u>Моргейжийн зээл</u>		<u>Хөдөө аж ахуйн зээл</u>	
	<u>Нийт дансны унэ</u>		<u>Нийт дансны унэ</u>	
	<u>Нийт</u> хугацаа	<u>12 сарын</u> хугацаа	<u>Нийт</u> хугацаа	<u>12 сарын</u> хугацаа
<u>0.00-0.10</u>	X	X	X	X
<u>0.11-0.40</u>	X	X	X	X
<u>0.41-1.00</u>	X	X	X	X
<u>1.01-3.00</u>	X	X	X	X
<u>3.01-6.00</u>	X	X	X	X
<u>6.01-11.00</u>	X	X	X	X
<u>11.01-17.00</u>	X	X	X	X
<u>17.01-25.00</u>	X	X	X	X
<u>25.01-50.00</u>	X	X	X	X
<u>50.01+</u>	X	X	X	X
<b><u>Нийт дун</u></b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

Х3У22Г. Хөдөө Аж Ахуйн Газар нь жижиг болон том тариаланчдын аль алинд богино хугацааны санхүүжилт олгодог. Санхүүжилтийн зорилго нь бордоо, ур, хортон устгагч гэх мэт орцуудыг худалдан авалтыг санхүүжүүлэх явдал юм. Хөдөө Аж Ахуйн Газар нь өөрийн жижиг тариаланчдын санхүүжилт ба том тариаланчдын санхүүжилтийг санхүүгийн хэрэглүүрийн тусдаа аngiud байдлаар толилуулдаг бөгөөд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дунгээр алдагдлын хасагдуулгыг ямагт хэмжихийн тулд худалдааны авлагын хувьд хялбаршуулсан хандлагыг хэрэглэдэг. Уг хялбаршуулсан хандлагын дагуу эрсдлийн төлөв байдлын тодруулга байдлаар Хасагдуулгын матрицыг хэрхэн ашиглахыг дараах хүснэгтэнд улгэрчлэн харуулсан:

<u>20XX он</u> <u>Мянган ТН</u>	<u>Худалдааны авлагын төлөгдөх хугацаа хэтэрсэн хоног</u>				
<u>Жижиг тариаланчдын</u> <u>санхүүжилт</u>	<u>Хэвийн</u>	<u>30-с дээш</u> <u>хоног</u>	<u>60-с дээш</u> <u>хоног</u>	<u>90-с дээш</u> <u>хоног</u>	<u>Нийт дун</u>
<u>Хулээгдэж буй</u> <u>алдагдлын хувь</u>	<u>0.10%</u>	<u>2%</u>	<u>5%</u>	<u>13%</u>	
<u>Үл биелүүлэлтийн үед</u> <u>тооцоолсон нийт</u> <u>дансын үнэ</u>	<u>20,777 TH</u>	<u>1,416 TH</u>	<u>673 TH</u>	<u>235 TH</u>	<u>23,101 TH</u>
<u>Нийт хугацаанд</u> <u>хулээгдэж буй зээлийн</u> <u>алдагдал-Жижиг</u> <u>тариаланчдын</u> <u>санхүүжилт</u>	<u>21 TH</u>	<u>28 TH</u>	<u>34 TH</u>	<u>31 TH</u>	<u>114 TH</u>
<b><u>Том тариаланчдын</u></b> <b><u>санхүүжилт</u></b>					
<u>Хулээгдэж буй</u> <u>алдагдлын хувь</u>	<u>0.20%</u>	<u>3%</u>	<u>8%</u>	<u>15%</u>	
<u>Үл биелүүлэлтийн үед</u> <u>тооцоолсон нийт</u> <u>дансын үнэ</u>	<u>19,222 TH</u>	<u>2,010 TH</u>	<u>301 TH</u>	<u>154 TH</u>	<u>21,687 TH</u>
<u>Нийт хугацаанд</u> <u>хулээгдэж буй зээлийн</u> <u>алдагдал-Том</u> <u>тариаланчдын</u> <u>санхүүжилт</u>	<u>38 TH</u>	<u>60 TH</u>	<u>24 TH</u>	<u>23 TH</u>	<u>145 TH</u>

- ХЗУ23. Байгууллага нь өөрийн зээлийн эрсдэл өргөлтийн талаархи мэдээллийг санхүүгийн хэрэглүүрийн аngiар тодруулахыг 43-р параграфаар шаардсан байдаг. Нэг ангийн санхүүгийн хэрэглүүрүүд нь уг тодруулга хийж буй эрсдлийн (энэ тохиолдолд зээлийн эрсдлийн) хувьд эдийн засгийн нийтлэг шинж чанаруудтай байдаг. Жишээлбэл; байгууллага нь орон сууцны барьцаат зээл, жэрэгжээний хөдөө аж ахуйн барьцаагүй зээл, арийжааны судалгаа ба хөгжлийн зээлийг тус бүрдээ эдийн засгийн өөр шинж чанартай гэж тодорхойлж болох юм.

...

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 1в

### УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

МЗҮ5-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 52Ж параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

#### Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 30-ийн салигүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

#### Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол

...

*Бусад тодруулга – Нягтлан бодох бүртгэлийн бодлого (25-р параграф)*

МЗҮ5. 25-р параграф нь санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан хэмжилтийн суурь (буюу сууриуд) болон тухайн санхүүгийн тайланг ойлгоход ач холбогдолтой, ашигласан нягтлан бодох бүртгэлийн бусад бодлогуудаа тодруулахыг шаарддаг. Санхүүгийн хэрэглүүрийн хувьд ийм тодруулгад дараах зүйлс хамаарч болох юм:

...

- (и) Бодит үнэ цэнийг нь тодорхойлж чадахгүй арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан бөгөөд анх хүлээн зөвшөөрөх үед УСНББОУС 41-ийн МЗҮ136-р параграфын дагуу алдагдлын хасагдуулгын дунгээр хэмжэдэг хасагдуултыг нь УСНББОУС 19, Нооц, Болэөшүүгийн Өр-Төлбөр ба Болэөшүүгийн Хөронго ийн дагуу байгуулсан санхүүгийн баталгааны гэрээний хувьд бодит үнэ цэнийг нь тодорхойлж чадахгүй байхад ингэж хасагдуулгыг хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн нөхцөл байдлын талаархи тодруулга.

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

52Ж. 2020 оны 01 дугээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар МЗҮ5-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 01 дугээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дугээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

#### Дүгнэлтийн Үндэслэл

#### 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтуудын үр дунд УСНББОУС 30-д хийсэн хянан засварлалт

ДҮ7. МЗҮ5-р параграфын нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн баталгааны гэрээний тайлагналтай холбоотой заавар удирдамжийг УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн үр дунд шинэчлэн баяжуулах

2019 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

бөгөөд УСНББОУС 41-ийг гаргах үед үүнийг санамсаргүйгээр орхигдуулсан байсан. УСНББОУСЗ нь эдгээр жижиг нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-1г

### УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д оруулсан нэмэлт өөрчлөлт

113-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 113А ба 154И параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

**Шилжилтийн үед үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд**

...

#### УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр

УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл шилжилтийн хугацаанд санхүүгийн хэрэглүүрийг ангилах

113. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 29-д заасан, ангиллын шалгуурыг хангадаг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг 44-р 113А параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр гэж ангилж болно. Анх удаа мөрдөж буй байгууллага нь ингэж ангилсан өдөр тухайн ангилал бүрээр тусгасан санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ, тэдгээрийн ангилал, дансны үнийг тодруулна.
- 113A. **УСНББОУС 41 нь анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн (хэрэв тодорхой шалгуурыг хангасан бол) санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр гэж ангилахыг зөвшөөрдөг. Энэхүү шаардлагыг үл харгалзан УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хэрэв санхүүгийн хөрөнгө нь УСНББОУС 41-ийн 44-р параграфт заасан шалгуурыг санхүүгийн өр төлбөр нь УСНББОУС 41-ийн 46-р параграфт заасан шалгуурыг хангаж байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү өдөр аливаа санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахыг түүнд зөвшөөрдөг гажих нөхцлүүдийг мөрддөг.**
114. УСНББОУС 29 нь анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн хөрөнгийг борлуулах боломжтой гэж ангилах, эсвэл санхүүгийн хэрэглүүрийг (хэрэв тодорхой шалгуурыг хангасан бол) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр гэж ангилахыг зөвшөөрдөг. Энэхүү шаардлагыг үл харгалзан дараах тохиолдолд гажих нөхцлүүдийг мөрддөг:
- (a) **Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр борлуулах боломжтой гэж ангилахыг түүнд зөвшөөрдөг.**
  - (b) **УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хэрэв хөрөнгө буюу өр төлбөр нь УСНББОУС 29-ийн 10 (6)(i), 10(6)(ii), 13-р параграфт заасан шалгуурыг хангаж байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү өдөр аливаа санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахыг түүнд зөвшөөрдөг.**  
**[Хассан]**

Хүчин тоголдөр болох хугацаа

...

154И. 2020 оны 01 дүгээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 113-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 113А параграфыг шинээр нэмсэн ба 114-р параграфыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтуудийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түнээс хойш эхлэх тайлант уеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтуудийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 41-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

## Дүгнэлтийн Үндэслэл

...

### 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтуудын үр дунд УСНББОУС 33-т хийсэн хянан засварлалт

ДҮ119. 113, 113А, 114-р параграфын нэмэлт өөрчлөлтууд нь аккруэл суурьт УСНББОУС-ыг анх мөрдөх үед санхүүгийн хэрэглүүрийг ангилахтай холбоотой заавар удирдамжийг УСНББОУС 41, Санхүүгийн Хэрэглүүр-ийн үр дунд шинэчлэн баяжуулах бөгөөд УСНББОУС 41-ийг гаргах үед үүнийг санамсаргүйгээр орхигдуулсан байсан. УСНББОУСЗ нь эдгээр жижиг нэмэлт өөрчлөлтуудийг 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 2

### УСНББОУС 13, Түрээс-т оруулсан нэмэлт өөрчлөлт

67 ба 76-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 85Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

#### Түрээслүүлэгчийн санхүүгийн тайлан дахь түрээс

...

#### Үйл ажиллагааны түрээс

...

67. Түрээслэсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохиын тулд байгууллага нь өлөн улсын ба/буоу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартад заасан, УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт эсвэл УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-ын аль тохиромжтой стандартын дагуу үнэ цэнийн бууралтын холбогдох сорилыг хийнэ.

...

#### Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ

...

76. Санхүүгийн түрээсийн хувьд (а) үнэ цэнийн бууралт гарсан, ба (б) үнэ цэнийн бууралтын талаар уг байгууллагын баримталдаг аливаа олон улсын ба/буоу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай байхаас бусад тохиолдолд ийм тохируулга хийх шаардлагагүй юм.

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 85Д. 2020 оны 01 дүгээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 67 ба 76-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2021 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеудийг хамарсан жилийн санхүүгийн тайландаа мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

#### Дүгнэлтийн Үндэслэл

...

#### 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтуудын үр дунд УСНББОУС 13-т хийсэн хянан засварлалт

- ДҮ9. Үнэ цэнийн бууралтын шаардлагууд нь олон улсын ба/буоу үндэсний нягтлан бодох бүртгэлийн бусад стандартуудыг биш, харин холбогдох УСНББОУС-ыг лавлагaa болгосон байх хэрэгтэй гэж оролцогч талууд мэдэгдсэн. 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-д УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт эсвэл УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч

2019 ОНЫ УСНББОУСЫН САЙЖРУУЛАЛТУУД

Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт гэсэн харилцан лавлагааг тусган оруулахын тулд УСНББОУСЗ нь 67 ба 76-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 3а

### УСНББОУС 13, Түрээс т оруулсан нэмэлт өөрчлөлт

84-р параграфыг хассан ба 85Е параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

#### Шилжилтийн нохцол

...

84. ~~УСНББОУС 13 (2001) ын шилжилтийн нохцол нь уг Стандартыг анх мөрдөөн одроос эхлэн бүх түрээнийг хүлээн зөвнөөрөхөд таван жилийн хүргэлих хугацааг байгууллагуудад олгодог. УСНББОУС 13 (2001) ыг омно нь мөрдөж байсан байгууллагууд нь уг УСНББОУС 13 (2001) ыг анх мөрдөөн одроос эхлэн энэхүү таван жилийн шилжилтийн хугацааны давуу талыг ашигласаар байж болох юм.~~  
[Хассан]

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 85E. 2020 оны 01 дугээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 84-р параграфыг хассан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлийг 2021 оны 01 дугээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеудийг хамарсан жилийн санхүүгийн тайландаа мөрдөнө. Дурдсан хугацаанаас омно мөрдөхийг зөвшөөрнө.

...

#### Дүгнэлтийн Үндэслэл

...

#### 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дунд УСНББОУС 13-т хийсэн хянан засварлалт

- ДҮ10. 84-р параграф нь түрээсийг хүлээн зөвшөөрөхөд таван жилийн хугацааг байгууллагуудад олгох шилжилтийн нохцлийг агуулсан байдаг. УСНББОУС 33, Аккруэл Сүурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийг гаргасны үр дунд эдгээр шилжилтийн нохцлуудийг хассан.

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 3б

### УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт

5-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 106-р параграфыг хассан ба 107C параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

#### Цар хүрээ

...

5. Энэ Стандартыг дараах үндсэн хөрөнгөнд мөрдөнө:

- (а) Зэвсгийн систем;
- (б) Дэд бүтцийн хөрөнгө; ба
- (в) УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл*: Эрх бүхий этгээд-ийн дагуу хийгдсэн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн дараах үйлчилгээний концессын хэлцлийн хөрөнгө.

~~95 104 р параграф дахь шилжилтийн нохцүүд нь бүх үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шаардлагуудаас таван жилийн шилжилтийн хугацааны туршид чөлөөлдөг.~~

...

#### Шилжилтийн нохцөл

...

106. УСНББОУС 17 (2001) гийн шилжилтийн нохцүүд нь бүх үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба хөлбөгдөх хэмжилт, тодрууллыг хийхэд зориулан уг Стандартыг анх мөрдсөн одроос эхлэн тав хүртэлх жилийн хугацааг байгууллагуудад олгодог. Өмнө нь УСНББОУС 17 (2001) г мөрдөж байсан байгууллагууд нь УСНББОУС 17 (2001) г анх мөрдсөн одроос эхлэн энэхүү таван жилийн шилжилтийн хугацааны давуу талыг үргэлжлүүлэн ашиглаж болох юм. Эдээр байгууллагууд нь 104 р параграфаар шаардсан тодрууллыдыг мөн үргэлжлүүлэн хийнэ. [Хассан]

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

107C. 2020 оны 01 дүгээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 5-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 106-р параграфыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеудийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

#### Дүгнэлтийн Үндэслэл

...

2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дунд УСНББОУС 17-д хийсэн хянан засварлалт

ДҮ15. 5 ба 106-р параграф нь таван жилийн хугацаанд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх боломжийг байгууллагуудад олгосон шилжилтийн нөхцлүүдийг тусгасан байдал. УСНББОУС 33, Аккруэл Сүүрьт Улсын Секторын Нягтлан Бодох Буртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийг гаргасны үр дүнд эдгээр шилжилтийн нөхцлүүдийг хассан.

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 4а

### УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-д оруулсан нэмэлт өөрчлөлт

54А ба 69А параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 82Л параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

#### Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих

...

54А. Дахин үнэлээгүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь УСНББОУС 31-д заасанчлан, бие даасан хөрөнгийн эсвэл УСНББОУС 17-д заасанчлан, тухайн хөрөнгийн ангийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээс хэтрэхгүй байх тэр хэмжээ хүргэл үнэ цэнийн бууралтын гарзыг уг дахин үнэлгээний нэмэгдэлд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн ийм үнэ цэнийн бууралтын гарз нь УСНББОУС 31-д заасанчлан, уг бие даасан хөрөнгийн эсвэл УСНББОУС 17-д заасанчлан, тухайн хөрөнгийн ангийн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна.

...

#### Үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах

...

69А. Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээний нэмэгдэлд шууд хүлээн зөвшөөрөх ба УСНББОУС 31-д заасанчлан, бие даасан хөрөнгийн эсвэл УСНББОУС 17-д заасанчлан, тухайн хөрөнгийн ангид хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг өсгөнө. Гэвч тухайн дахин үнэлсэн бие даасан хөрөнгөнд эсвэл дахин үнэлсэн хөрөнгүүдийн ангид хамаарах үнэ цэнийн бууралтын гарзыг өмнө нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн тэр хэмжээгээр уг үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг УСНББОУС 31 эсвэл УСНББОУС 17-гийн дагуу мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

82Л. 2020 оны 01 дүгээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 54А ба 69А параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мордоно. Дурдсан хугацаанаас өмнө мордохийг зөвшөөрнө.

...

#### Дүгнэлтийн Үндэслэл

...

#### 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтуудын үр дунд УСНББОУС 21-д хийсэн хянан засварлалт

ДҮ27. 54А ба 69А параграф дахь “хөрөнгүүдийн анги” хэллэг нь тухайн заавар удирдамж зөвхөн УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө-ийн цар хүрээнд хамаарах, дахин үнэлсэн хөрөнгүүдэд мөрдөгдөнө гэсэн сэтгэгдэл төрүүлж байсан. Оролцогч талууд нь дахин үнэлсэн биет бус хөрөнгөнд түүнийг

2019 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

мердөхгүй хасаж байна гэсэн санааг илэрхийлсэн. Иймээс эдгээр параграфуудыг УСНББОУС 31-ийн цар хүрээнд хамаарах бие даасан хөрөнгүүд болон УСНББОУС 17-гийн цар хүрээнд хамаарах хөрөнгүүдийн ангид мөрдөнө гэдгийг УСНББОУСЗ нь тодорхой болгохыг зөвшөөрсөн.

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 46

### УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-д оруулсан нэмэлт өөрчлөлт

73А ба 108А параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 126Н параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

#### Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих

...

73А. Дахин үнэлээгүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь УСНББОУС 31-д заасанчлан, бие даасан хөрөнгийн эсвэл УСНББОУС 17-д заасанчлан, тухайн хөрөнгийн ангийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээс хэтрэхгүй байх тэр хэмжээ хүртэл үнэ цэнийн бууралтын гарзыг дахин үнэлгээний нэмэгдэлд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн ийм үнэ цэнийн бууралтын гарз нь УСНББОУС 31-д заасанчлан, уг бие даасан хөрөнгийн эсвэл УСНББОУС 17-д заасанчлан, тухайн хөрөнгийн ангийн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна.

...

#### Үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах

...

#### Бие даасан хөрөнгийн эсвэл хөрөнгийн ангийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах

...

108А. Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээний нэмэгдэлд шууд хүлээн зөвшөөрөх ба УСНББОУС 31-д заасанчлан, уг бие даасан хөрөнгийн эсвэл УСНББОУС 17-д заасанчлан, тухайн хөрөнгийн ангийн хувьд дахин үнэлгээний нэмэгдлийг өсгөнө. Гэвч тухайн дахин үнэлсэн бие даасан хөрөнгийн эсвэл дахин үнэлсэн хөрөнгүүдийн ангийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг өмнө нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн тэр хэмжээгээр уг үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг УСНББОУС 31 эсвэл УСНББОУС 17-гийн дагуу мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

126Н. 2020 оны 01 дугээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 73А ба 108А параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтийг 2021 оны 01 дугээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеудийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

#### Дүгнэлтийн Үндэслэл

...

2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтуудын үр дунд УСНББОУС 26-д хийсэн хянан засварлалт

ДҮ21. 73А ба 108А параграф дахь “хөрөнгүүдийн анги” хэллэг нь тухайн заавар удирдамж зөвхөн УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө-ийн цар хүрээнд хамаарах, дахин үнэлсэн хөрөнгүүдэд мөрдөгдөнө гэсэн сэтгэгдэл төрүүлж байсан. Оролцогч талууд нь дахин үнэлсэн биет бус хөрөнгөнд түүнийг мөрдөхгүй хасаж байна гэсэн санааг илэрхийлсэн. Иймээс эдгээр параграфуудыг УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө-ийн цар хүрээнд хамаарах бие даасан хөрөнгүүд болон УСНББОУС 17-гийн цар хүрээнд хамаарах хөрөнгүүдийн ангид мөрдөнө гэдгийг УСНББОУС З нь тодорхой болгохыг зөвшөөрсөн.

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 5

### УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д оруулсан нэмэлт өөрчлөлт

ХЗҮ39-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

#### Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салигүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

#### Төсөөлөн тооцсон өртөг

ХЗҮ39. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байх гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа олгодог шилжилтийн нехцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх худалдан авалтын өртөг буюу элэгдэл тооцсон өртгийн орлуулагч байдлаар төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохыг УСНББОУС 33-аар зөвшөөрсөн байдаг. Гэвч тухайн хөрөнгө, өр төлбөрийн түүхэн өртгийн талаархи мэдээлэл бэлэн боломжтой байхгүй зөвхөн тийм үед төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болох юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр тэдгээр хөрөнгийг ба/буую өр төлбөрийг анх хэмжсэн үед, эсвэл зарим хөрөнгийг ба/буую өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн хугацаа дууссан тохиолдолд тус байгууллага нь төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлсон тайлант үеийн эхлэлийн санхүүгийн байдлын тайлан дахь хуримтлагдсан ашиг, алдагдалд алдагдлын эхний үлдэгдлийн тохируулга байдлаар түүний үр нөлөөг шууд дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (а) Төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлсон тайлант үеийн эхлэлийн санхүүгийн байдлын тайлан дахь хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдлийн тохируулга байдлаар; эсвэл
- (б) Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 17 эсвэл УСНББОУС 31, Биет Бүс Хөрөнгө д заасан, дахин үнэлгээний загварыг ашигладаг бол дахин үнэлгээний нэмэгдэлд.

...

## Нэмэлт өөрчлөлт: Хэсэг 6

### УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-д оруулсан нэмэлт өөрчлөлт

126В, 126Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур зурсан.

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

126В. Байгууллага нь УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д тодорхойлсон, аккруэл суурьт УСНББОУС-удыг энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш санхүүгийн тайлагналын зорилгоор мөрддөг тохиолдолд уг УСНББОУС-удыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан тухайн байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

126Г. 2020 оны 01 дүгээр сард гаргасан, 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 126В параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

#### Дүгнэлтийн Үндэслэл

...

#### 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дунд УСНББОУС 40-д хийсэн хянан засварлалт

ДҮ94. УСНББОУС 40-ийг гаргах үед УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-тэй холбоотой уг параграфыг санамсаргүйгээр орхигдуулсан байсан. УСНББОУСЗ нь УСНББОУС 33-тай нийцүүлэхийн тулд 126В параграфыг шинээр нэмж оруулсан.

## ЗОХИОГЧИЙН ЭРХ, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Саналын Төсөл, Зөвлөлдөх Баримт Бичиг, Санал Болгосон Практик Удирдамж болон УСНББОУСЗ-ийн бусад хэвлэлүүдийг ДНБХ-оос хэвлэн гаргасан бөгөөд түүний зохиогчийн эрхэд хамаарна.

Энэхүү хэвлэлд тусгагдсан материалуудад итгэл үзүүлэн үйлдэл хийсэн эсвэл үйлдлээ больсоны улмаас хэн нэгэнд хохирол учирсан тохиолдолд хохирол нь хайнга байдал буюу бусад шалтгаанаар үүссэн эсэхээс үл хамааран УСНББОУСЗ болон ДНБХ нь уг хохирлын хувьд хариуцлага хүлээхгүй болно.

‘International Public Sector Accounting Standards Board’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл), ‘International Public Sector Accounting Standards’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт), ‘Recommended Practice Guidelines’ (Санал Болгосон Практик Удирдамж), ‘International Federation of Accountants’ (Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо), ‘IPSASB’ (УСНББОУСЗ), ‘IPSAS’ (УСНББОУС), ‘RPG’ (СБПУ), ‘IFAC’ (ДНБХ), ‘IPSASB’ гэсэн лого, ‘IFAC’ гэсэн лого нь АНУ болон бусад улс орнууд дахь ДНБХ-ны худалдааны тэмдэг буюу бүртгэгдсэн худалдааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2020 оны 01 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү баримт бичгийг хувилан олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд ДНБХ-ноос бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай. [permission@ifac.org](mailto:permission@ifac.org) хаягаар хандана уу.

ДНБХ-ноос хэвлэв





**Улсын Секторын Нягтлан  
Бодох Бүртгэлийн Олон  
Улсын Стандартын Зөвлөл<sup>TM</sup>**

529 тавдугаар ёргөн чөлөө,  
Нью Йорк, Нью Йорк 10017  
Утас: +1 (212) 286-9344  
Факс: +1 (212) 286-9570  
[www.ipsasb.org](http://www.ipsasb.org)